

ГАДААДЫН ХЭВЛЭЛИЙН
ХУУДАСНААС

**БОДОЛД УРГАСАН
ЯРИЛЦЛАГА***

Д. Н. ГУМИЛЕВ

Түүхийн ухааны доктор, профессор

Өөрчлөн байгуулалтын өнөө үед ардчилал, шинэ сэтгэлгээ, ил тодын шимтэй хөрс, эрүүл саруул уур амьсгалын увидасаар дахин төрөх хүчийг олсон зөвлөлтийн хэвлэлийн газрууд сталинизмын аймшигт жилүүд, зогсонги байдлын урт ужиг онуудад зарим яруу найрагч, зохиолч, сэтгүүлч, нийтлэгч, түүхч эрдэмтэд зэрэг бүтээлч сэхээтний зөвхөн ширээний нүднээс цааш алхаж чадаагүй хэдэн арван боть номыг нэхэн нийтлэх ажилд ороод байна. Цаг цагаа дарж чадахаас биш, цаг хүний, цагт биш, хүндээ зориулсан бүтээлч ариун хөдөлмөрийн үр шимийг дарж чаддаггүй нь ийн билээ. Цаг хүнийг үхүүлж чадах авч, цаг үзэл бодлыг үхүүлж чаддаггүй нь ийн билээ.

Зөвлөлтийн нэрт түүхч Л. Н. Гумилевын угсаа-гарлын онолын үүднээс туурвисан хоёр томоохон бүтээл 1989 онд Москва, Ленинград хотуудад зэрэг нийтлэгдэх болсныг саяхан хэвлэлийн хуудас уламжлалаа. Бид сэтгүүлийнхээ энэ дугаарт Лев Николаевич Гумилёвын «Апокрифический диалог» хэмээх онцгой сонин зохиомжоор бичсэн нийтлэл өгүүллийг Бодолд ургасан ярилцлага» нэрийн дор орчуулан тавьж уншигчдаа толилуулж байна.

Д. МААМ

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Миний казах анд зэгсэн боловсролтой, авьяаслаг урлаг судлаач өөрийн үзсэн бяцхан явдлыг надад нэгэнтээ хүүрнэж билээ. Хээрийн хайгуулын замд мань хүн олон казахтай (тэр дотор дээд боловсрол эзэмшсэн, нийгмийн өндөр байр суурьтай хүмүүс ч байж) хоног тааран галыг тойрч шөнийг өнгөрөөх болжээ. Тэдний дунд Чингис хааны удам угсааны нэгэн зүдүү өвгөн байсан гэнэ. Тал нутагт түүний мэт хүмүүсийг хүндэтгэдэг тухай өгүүлэхийн хэрэг юун.

Шаагсан архитай ширээнд шуугиж байсан олон удам угсааны маргаанаас болж хэрүүлийн хатуу үг шидэлцэж эхэлсэн байна. Хутга хуйнаас сугарч, лонх шидэгдэн, шил бутарч... ер нь л юм юм болжээ. Өвгөн үсрэн босч: «Чингис-дык роух шакрым!» гэж хашгирсан гэнэ. Энэ нь «Чингисийн сүр сүлд та нарыг үзэж, сонсож байгаа!» гэсэн үг. Дорхноо хүмүүс эрүүлжин хутгаа хуйлсаар тарж одоцгоосон байна. Энэ бол сургамж Боловсрол, хүмүүжлээс үл хамааран хэн маань ч өөрцгүй өөрийн оюун санааныхаа нэгэнтээ өнгөрсөн түүхийн их ачааг үүрч явдаг билээ.

Проф. М.Е. Лобашевын нээсэн «дохиогоор үе залгамжлах» чанар, цусны эргэлт, амьсгалын вегетатив ч юм уу нервийн системийн альхан нэгэн хэсэгт хоргодогч генетикийн далд зөн, мөн өвөг дээдсийн тухай түүхийн дурсамж бодол нь үндэстэн, ард түмнүүдийн араншин байдлыг төлөвшүүлэхэд оролцдог ажгуу.

Энэхүү үе залгамжлах чанар нь илэрч гарахдаа машид нарийн. Парижийн нэгэн цайны газар дээрхийн адил маргаан гарчээ гэж төсөөлөө. Тэнд бол овгийн үндэс дээр муудалцах учиргүй. Учир нь францчууд ов-

* «Нева» сэтгүүлийн 1988 оны № 3, 201 — 207-р тал

гийн байгуулалгүй улс. Бүр 841 оноос тодорсон тэдний өвөг дээдэс галлоромчууд ч овоггүй л байлаа. Ер нь гэвэл францчууд улс төрийн үзэл бодлын зөрөлдөөнөөс л болж муудалцах хүмүүс. Юу ч л гэсэн Үзэсгэлэнт Филипп Сэцэн Карл, тэр ч байтугай Наполеоны сүр сүлдийг хичнээн хашгирч дуудаад согтуурхан эвдрэлцсэн францчуудыг эрүүлжүүлж, ч, эвлэрүүлж ч дийлэхгүйсэн болов уу.

Өөр омог цусны хүмүүстэй эе данг барихын барихын учир юунд хэрхэн хандах мах ясны нь мөн чанарыг анхаарч, уцаар гомдлыг нь хөгжөөж хөөрөгдөх үг, явдлаас зайлсхийх хэрэгтэй. Ингэж чадаагүйгээс хичнээн авьяаслаг жуулчид амиа золиослосныг тоолов ч баршгүй. Харилцан үл ойлголцсоноос, эсвэл хүмүүс бүгд адил, би эдэнтэй яг ижил гэх мунхаг мэдэмхийрлээс шалтгаалан хичнээн цуст мөргөлдөөн болж өнгөрснийг бүү мэд.

Алив ард түмний шинжлэх ухаанд нууцгүй болсон дүр төрх, үндэстний онцлог нь тойрон буй орчноор төдийгүй, түүний зан үйл, хөгжил хөдөлгөөний хуучин намбыг бүрэлдүүлэлцсэн хуримтлагдмал өнгөрсөн үеэр дутуугүй хэмжээнд тодорхойлогддогийг санууштай. Хэвийн хэрэггүй мөчөөрхөл, эмгэнэлт үл ойлголцох явдлаас холуурхан тойрѐ гэвэл газар зүй, биологи, түүх, сэтгэл зүйн зэрэг салбарын нэгдэл болсон угсаатны зүйн гүн өргөн мэдлэг бидэнд хомсдон үгүйлэгдэж байгааг сэнхэрмээрсэн билээ. Эл шинжлэх ухааны амьдралын учир холбогдол цаашид гүнзгийрэн тодотгогдох байхаа гэж би итгэнэ.

Одоо тюрк-монголчуудын түүх, тэдний байлдан дагууллын үйл явдалд зориулж буй өгүүллийнхээ гол сэдэв рүү орж ярилцъя.

Тюрк-монголчуудаас XIII зуунд явуулсан аян дайн тэдний эргэн тойрны ард түмнүүдэд үлэмжийн их сэтгэгдэл төрүүлсэн юм. Гагцхүү энэ талаар түүхчид хэт олон янз бичжээ. Зарим нь сэтгэлийн хөдөлгөөнөө гол болгосноос бус эрдэм судлалын эрэл хайгуул хийсэн нь огтоос ажиглагдахгүй байна.

Эрт дээхэн үеийн Хятадын зохиогч нар үйл явдлын урсгалыг их л хуурай, барьж тавьсан шинжтэй хүүрнэсэн байдаг. Дайн бол байгалийн үзэгдэл, «тэнгэр» соёрхсон үймээн гэх үзэл Хятадад ноёлж байсан болохлоор энэ ч бас ойлгомжтой хэрэг.

Ойрхи Дорнодахинд гэвэл армянчууд монголчуудыг өөрийн холбоотноо хэмээн, тэдний талаар өнгө найруу бүлээн дулаан аясаар бичиж байв. Харин лалтангууд дорно зүгийн христос шашинтан-монголчууд нь армян, айсор зэрэг христос сүсэгтнүүдийг талархдаг, мөн грекүүдтэй найртай явсан гэж дургүйлхэн, Монголын тухайд их л зэвүүрхэл жигшилтэйгээр бичиж тэмдэглэсээр иржээ. Эртний Оросод гэвэл он дарааллын судар туурвигчдын монголчуудын талаарх эсрэг хандлага XII зуунд биш, бүр хожуу зуун жилийн дараа, яг хэлбэл засгийн эрхийг хууль бусаар булаагч Мамой катологчуудтай хэлхээ холбоо барилдан, үнэн алдарт Москваг сээрэлхэж байсан тэр үеэс илрэх болсон байна.

Монголын эсрэг чиглэсэн орос ардын аман зохиол ч Чингисийн эрин үетэй огтоос хаялгагүй бөгөөд Хар тэнгисийн татар, ногайчууд Литовын ба Оросын украиныг уулгалж байсан гурван зуун жилийн хэрэг явдлын толь тусгал болж үлдсэн аж. Харин энд шударга ёсны үүднээс запорож болон донын казакууд ногайчуудын булаан дээрэмдэх уулгалааныг эрэл хэгээр сөрөн тэмцэлдэж, хоёр талын аль аль нь ялгуусан баатарлаг цэрэг эрстэй байсныг тэмдэглэн өгүүлэлтэй.

Гэвч ер бусын гайхалтай нь тюрк-монголчуудыг, ялангуяа Чингисийг Баруун Европын роман-германчууд хамгаас илүү үзэн ядаж ирсэн явдал

мөн. Энэ бол үнэхээр хачирхалтай бөгөөд зүйд нийцэхгүй мэт үзэгдэл. Юу гэвэл, тэр ард түмнүүд Чингистэй хэзээ ч тулгарч байгаагүй, тэгээд ч монголчууд тэднийг хэзээ ч байлдан дагуулж явсангүй.

Гэсэн хэдүй боловч монголчууд мөн түрк угсаатан, нар, тэрч байтугай оросууд нь гай гамшигт эрлэгүүд мөнөөс мөн гэх итгэл үнэмшил чухамхүү Баруун Европт таван зуун жилийн турш ургаж цэцэглэж, бэхжиж төлөвшжээ. Энэхүү явцуу үзэл бодлыг арьсны үзлийн хувилбараар оноон тайлбарлаж болох авч, хэргийн учир тийм ч гүехэн хялбар бус байгаа нь ажиглагдана. Юу хэмээвээс католок Европ нь арабууд, османы туркууд гай мянган жилийн турш дайн хийсэн байхад тэдний тухай дээрхийн адил үзэл баримтлал Европод төрж төлөвшөөгүй байх юм. Монголын аюумшгаас айх өвчин өөрийн тааваар аж төрж ирсэн агаад европын түүх бичлэгт ямархуу тод томруун байр суурь эзлэхээ өөрсдөө ч төсөөлөөгүй явсан сибирийн ард түмнүүдийг үзэн ядах явдлыг европынхонд бий болгосон нь дээрхтэй хаялага бүхий өөр нэг онцлог байна.

Энд өгүүлэн бүхий европын түүх бичлэгт XIII зууны монгол тулгар төрийн үүсгэлийг тайлбарлахдаа энэхүү түүхэн үйл явдлыг эрин цагийн гай гамшиг хэмээн үзсэн тогтолцоот үзлийн гурван зүйл хувилбар төлөв шин уламжлагджээ.

Нэгдүгээр хувилбарт: Хаан сууж Чингис хэмээн өргөмжлөгдсөн Тэмүүжин нь дээрэмчдийн бүлгийг эмхэтгэн толгойлж, Ази дахины бүхий нүүдэлчин ард түмнийг эрхшээлдээ оруулахаар сүүлд хөвгүүд, ач нар нь залган авч үргэлжлүүлсэн олон тооны дайныг хувийн явцуу эрх ашиг, баяжиж хөрөнгөжихийн төлөөнөө л хийсэн байна — гэнэ. Гэхдээ тогтолцоот үзлийн энэхүү хувилбараас Чингис хэрхэн яаж тэр бүхнийг гүйцэлдүүлж амжсан тухай мэдэхийн аргагүй юм.

Хоёрдугаар хувилбарт: Бүх монголын ард түмэн дээрх гэмт хэргийг нэгэн санаа зоригор үйлджээ, — гэнэ. Гагцхүү энэ бүхэн монголчуудад юуны учир хэрэгтэй байсныг ойлгоход нэгэн адил бэрх. Довтлон дайтаж яваа цэрэг эрс тэр болгон олз омгийг эх нутагтаа тээж харина гэдэг боломжгүй хэрэг шүү дээ.

Гуравдахь хувилбарт: Нүүдэлчид дөрвөн цагийн эргэлтэд хөдөлмөрт уртай тариачдыг довтлон түйвээж ирснээс ургуулан бодохуй, монголчуудын үйл ажиллагаа нь дан ганц гэмт хэрэг төдий биш тэдний амьдрал ахуй дундаас төрж гарсан онцлог юм, — хэмээнэ. Иймэрхүү үзэл бодол Библи сударт ч бас өгүүлэгджээ. Тэнд гагцхүү асуудал эсрэгээр шийдэгдсэн байх бөгөөд яг хэлбэл Кан Авелийн амь насыг бүрэлгэж, үүнийхээ учир яллагддаг. Баруун Европын түүх бичлэгт гэвэл Авель ялагдаж, Кан цагаатгагдаж байна!

Энэхүү өгүүллийг зохиогч нь нэг бус удаа маргаанд оролцож буурь суурьтай агаад юмыг эргэцүүлэн боддог мэргэд, гүехэн мэдлэгтэнгүүд, ёсорхог араншин бүхий сурвалж зохиол судлаачид, Дорнодын ба Оросын түүхийн гүн ухаантангууд, ер нь л янзын хүмүүстэй санал солилцож, бодол уралдуулж явсан билээ. Иймд тэдгээр хүмүүсийн ерөнхий эсэргүүцэлд эл өгүүллээр хариу өгөхийг оролдлоо.

За ингээд миний бодолдоо ургуулсан хилэгнэлт профессор намайг хэрхэн няцааж, яахан буруутгах гэхийг одоо сонсьё.

Профессор: Та Чингис хааны тухай нэг биш удаа бичсэн. Гэхдээ Чингис хаанд ч, хазгар Төмөрт ч зохих ёсны үнэлэлт дүгнэлтийг өгсөнгүй. Яагаад тэр билээ?!

Зохиогч: Шинжлэх ухаан болбоос худалдагдах эд бараа бүхэн сайн үнийг «сонсож» болдог зах зээл биш юм. Би түүхэн хүмүүсийн нэрээр панз үсэргэж яваагүй нь үнэн.

Судлагдан бүхий юмс үзэгдлийн учир чанар үнэлэгдэхдээ биш, салагдахдаа байдаг. Нөгөө талаар монголчуудын их хаан Чингис, Цагаадайн улсын ван Төмөр хоёр түүхэнд чухмаас эсрэг тэсрэг байр суурь эзэлж байсныг тэмдэглэлтэй. Чингис цаг зуураар өөрт нь цохигдож асан хүчирхэг агаад өр зузаан хөршүүдээсээ ард түмнээ өмгөөлж хамгаалж байсан бол Төмөр Чингисийн удмын хойт үеийн нүүдэлчидтэй харгалдаж, нэгэн зэрэг хөрш зэргэлдээ суурьшсан улс орнууд руу дээрмийн довтолгоон хийж явлаа. Тэдний хооронд тэгшитгэж адилтгах зүйл нэгээхэн ч үгүй.

Профессор: Иймэрхүү байлдан дагуулагчдын түүхэнд гүйцэтгэсэн гэх эерэг үүрэг холбогдлын тухай ингэж ярьж болно гэж үү?

Зохиогч: Мэдээжийн үгүй. Адил хэмжээнд цэг аль зүг шугам ба татагдсан тухай ярьж бас яахин болох билээ. Дэвшил бол урагшлах нэр, эсрэг үзэгдэл (регресс) нь ухрахын нэр. Хажуу тийш хальсан хөдөлгөөнд юу гэсэн нэр оноох вэ? Гуйвах дайвах хөдөлгөөн гэх үү дээ. Нүд алдам талд луужингүйгээр явагч хэн болгон шугам шиг шулуун урагш чадахгүй. Тэр ч байтугай үүлнээс буун орж ирж байгаа борооны дуслын хөдөлгөөн шулуун байдаггүй юм. Алдаа эндэгдэл нөхөгдөж засагддаг учир амьдралд дээрх үзэгдэл төдий л учир холбогдолтой биш мэт бидэнд санагддаг авч замын тодорхой нэгэн зурвас хэрчимд л тийм байгаа. Түүхэнд ч эл байдал ажиглагддаг юм. Хоёр, гурван зуун жилийн зайд ба дэвшил хөгжлийн тухай ярьж болно. Хорь гучин жилийг таслан үзвэл их төлөв гуйвах дайвах хөдөлгөөнийг л бид харах болно.

Профессор: Тэгэхлээр та суурьшсан ард түмнүүдийн эсрэг зэрлэг нүүдэлчдээс явуулсан өргөн цар хүрээтэй байлдан дагууллыг хов хоосон зүйл гэж үнэлэх гээд байнаа даа?! Ангийн тэмцлийн хууль хаачлаа?!

Зохиогч: Омог отгийн шатанд байсан монголчуудын байлдан дагуулал 1200—1260 онд явагдаж өнгөрсөн бөгөөд үүний дараа тэд өөр хоорондоо дайсагналцаж, бие даасан таван улс болон задарсан билээ. Эдний дөрөв нь феодалын улсууд болж хөгжсөн. Ерөөс нийгэм-эдийн засгийн хар шат нөгөөгөөр солигдох нь сунгуу холын дуншаа явдал байдаг. Хөгжлийн нэг шатнаас нөгөөд шилжихэд үйлдвэрлэх хүчний өсөлт, үйлдвэрлэлийн харьцааны эргэлт шаардагддаг хийгээд харин мал хариулгын энгийн аж ахуйд иймэрхүү үзэгдэл байдаггүй юм. Тийм ээ, Хятадад төвлөсөн Юань гүрэн, Иран дахь илхаадын улс, Волгын дагуух Алтан орд Дунд Ази дахь Цагаадайн хаант улсад монголчуудын морины туурай гишгэхээс өмнө феодализм цэцэглэж байсан нь үнэн хэрэг. Гэтэл нутгийн монголчууд нь гадаад орны үй олон дунд уусаж хайлаагүй, Зүүн гарын хант улс хөгжлөөрөө ангит нийгмийн өмнөх үеийн цэргийн ардчиллын шатанд оршиж байв. Түүхийн материализмын онолыг шантлан няцаах ямар учир Танд байгааг би харин ойлгохгүй юм!

Профессор: Зэрлэгүүд соёлт муж, хотуудыг түйвээн устгасан явдлыг Таны сайрхан хамгаалж байгааг чинь би ч бас ойлгохгүй байна.

Зохиогч: Тэгээ ч үгүй, тэгэхийг хүсэх ч үгүй. Зөрчид нар Хойт Хятадыг 1114-1140 оны завсар байлдан дагуулсан. Энэ бол монголчуудаас зуун жилийн өмнөх явдал. Дунд Ази, Ираныг эхлээд сельжук (туркменчууд) нар, дараа нь Кангли хэмээх печенгийн омог угсаатанд тулгуурласан хорезмшахынхан хоослон дээрэмджээ. Монголчууд гэвэл тэд нартай л байлдсан. Баян бүрд, худалдаа, соёлын өлгий нутаг уйгарын тухайд бол Монгол тэдэнд огт гар хүрсэнгүй.

Профессор: Хар-хотын үнсэн товрого болсон туурийг юу гэх вэ?

Зохиогч: Эзэн-ай буюу бас монголоор Урахай хэмээх Тангадын энэ хот 1227 онд Чингис хааны дайлаар авсаны дараа бүтэн зуун жил буюу хятадууд очиж нурмы нь хийсгэх цаг хүртэл цэцэглэн хөгжиж байсан юм шүү. Түрэмгийлэгчид эзний голын гольтрогийг өөрчилсөн. Монголчуудад тэгэх багаж зэвсэг байгаагүй юм.

Профессор: Тэгвэл, XV зууныг хүртэл Оросыг нугачилсан монголын дарлалыг та юу гэж үзэж байна?

Зохиогч: 1237—1240 онд болсон Батын байлдан дагууллын дараагаар бөөгийн шашинт монголчууд (тэдний дунд олон тооны христос номын хүмүүс байсан) оросуудтай нөхөрлөж, Прибалтикт германуудын довтолгоог зогсооход нь тэдэнд тусалж байжээ. Узбек, Жанибек мэт лалын хаадууд Москваг олз завшлын эх булаг болгон ашиглаж байсан хэдүй ч Литвийн довтолгооноос хамгаалж байжээ. Нөгөө талаас Алтан ордны улсуудын эвдрэл буюу тэр үеийн хэлээр «их үймээн» гэгч болж орд нь хүчин доройтохын цагт оросын вангууд ордыг туслаж тэтгэж явжээ. Тогтамышийн ноёрхолын үед Төмөр Алтан ордыг уулгалснаас хойш Орд дахин сэхээгүй юм.

Улс гүрнүүдийн хоорондох дайн байлдаан ард түмнүүдийн дунд харилцан үзэн ядахын уур амьсгал буй болгох нь байдаг. Ийм хөнөөлт уур амьсгал урт ужиг хугацаанд үргэлжлэх нь ч бас бий. Үүнийг Ольстерын сургамж нотолно. Ирландчууд XVII зуунд Дрогед нутгийнхныг хүйс тэмтэрсэн Кровелийн яргаллыг ер мартдаггүй билээ. Аз болоход Орос Монголын хооронд тийм үзэн ядах ужиг өвчин дэлгэрсэнгүй. Олон монгол-татарууд цус холилдох замаар оросын ард түмэнд нийлж нэгджээ. Лалын шашинтан болсон хэсэг нь Казанд оросуудтай эв түнжин нэг, элэг бүтэн амьдарч байна.

Казахууд XVIII зуунд сайн дураар Орос улстай хилээ задалсан. Узбек, Туркменүүд гэвэл иргэний дайны хүнд жилүүдэд бутарч бултрахгүйгээр Оростой чингэж хатуу барилдсан байлаа. Ард түмнүүдийн ийм нэгдэл холбоог «талхи дарлал» (зохиогч «Монгол-татарын талхи дарлал» «монголо-татарское иго» гэдэг ихэд дэлгэрсэн нэр томъёог энд шүүмжлэлтэйгээр авч хэрэглэсэн бололтой. -орчуулагчдын тайлбар) гэж оноож нэрлэж болох уу даа! Ийм ч учраас баруун зүгийн герман, литов, мажаруудын довтолгооны эсрэг татартай харилцан туслалцах гэрээ хэлэлцээр тогтоож байсан гэж оросын вангуудыг буруутган зэмлэх газаргүй юм. Ерөөс ах дүү ард түмнийг «зэрлэг дээрэмчдийн үр удам» гэж зүхээд байдаг маань ер юу болж байна! Тийм ээ, тэд үнэхээр хатуу дайн хийж байсан. Тэгэхдээ л цаг нь хатуу байсан гэдгийг санацгаая. Зүгээр л татарууд өөрийн дайснаас илүү дайчин чадмаг байлдаж байлаа. Чингэлээ гэж тэднийг буруутгах нь юу билээ? Та юу гэж бодно?

Профессор: Би ер нь Тантай ярилцаж чадахгүй нь. Таны өнгөрснийг үзэх үзэл биологи хүчинд хэт автжээ. Иймээс нийгмийн хөгжлийг тодорхойлоход мөхөсдөж байгаа бололтой.

Зохиогч: Энэ бол зөвхөн миний ч биш, бас К. Маркс, Ф. Энгельсийн үзэл юм (Зохиолуудын 46-р боть, 1 анги, 462—463 дахь тал). Байгалийн үзэгдэл нийгмийн хөгжлийг тодорхойлохгүй нь мэдээж. Нийгмийн хөгжил өөрийн зүй тогтолын дагуу явагддаг бөгөөд харин Марксын хэлснээр үндэстэн ястны бүрэлдсэн зам нь нийгмийн хөгжлийн урьдчилсан нөхцөл болдог учиртай эртний хүмүүс олз омог ихтэйгээр ангуучлан, махчин амьтдаас биеэ хамгаалахын тул бүлэг сүргээрээ амьдардаг байлаа.

Үндэстэн ястан нийгмийн шатуудыг нэвтрэн өнгөрч эдүгээ ч оршин тогтносоор л байна. Этногенез (этносын үүсэл, усталт) нь хэдүй байгалийн үзэгдэл мөн боловч нийгмийн хөгжилтэй харилцан нөлөөлөх зохицол жамтай. Этногенез болбоос хүн төрөлхтний ерөнхий хөгжил (дэвшил, буурал)-ийн тахир шугам юм. Үүнтэй маргахын аргагүй биз.

Профессор: Үгүй, маргахгүй. Би бол нийгмийн ухааны эрдэмтэн, энэ байгалийг чинь мэдэх ч үгүй, мэдэхийг хүсэх ч үгүй. Та надад, буян гэж юу вэ, хорлол гэж юу вэ гэдгийг л тодорхойхон хэлээд өг!

Зохиогч: Байгалийн үзэгдэлд үнэлэлт цэгнэлтийн категори гэж байдаггүй юм. Тэнгэр дүнсийх, салхи шуурга босох, эсвэл ган зуд, үерийн аль аль нь бидний санаа зоригоос эс шалтгаална. Нөлөө хүчнээс нь сэргийлэхийн учир тийм үзэгдлүүдийг анхааран судалдаг билээ. Үүний тул метеорологи хэмээх цаг уур судлалын шинжлэх ухаан бий. Харин түүхийн газарзүй бол хүн-орчин (антросфера) судлалын шинжлэх ухаан юм. Хүн орчны явдлыг судлаж болох авч үнэлэх гэсний хэрэггүй. Хүн орчны хүрээнд болж байгаа ард түмнүүдийн хувьсал өөрчлөлт, нүүдэл суурьшлын гэх зэрэг асар үйл явдлуудыг хүмүүс үүсгэж ч болохгүй, зайлуулж ч чадахгүй. Энэ бүхнийг анхаарч тооцоолох замаар ийм үйл явдлуудын эцсийн томоохон нөлөө холбогдлоос зайлсхийж харин болохсон биз ээ. Тухайлбал галт уулын дэлбэрэлтийн цагийг урьдаас тооцоолж мэдсэнээр хүн амыг аюулгүй бүс нутагт нүүлгэн суурьшуулах арга хэмжээ авч болдогтой энэ нь үлгэр нэгэн явдал

Одоо хянуур нэгэн хуучлагчийн яриаг сонсьё. Энэ бол урлаг судлаач хүн.

Урлаг судлаач: Хүн төрөлхтний бүтээсэн бүх зүйлийн дотроос хамгийн үнэтэй нь соёл, тэр дотроо урлаг юм. Хоттой нь, сүмтэй нь, баатруудтай нь, түмэн үеийн ёс, вангуудаа дээдлэх хүндэтгэлтэй нь би эртний Оросоо хайрлаж явдаг хүн. Бидний өвөг дээдэс монголыг нэгээхэн ч гомдоосонгүй. Гэтэл тоо томшгүй монгол цэрэг XIII зуунд манай буурал соёлын өв, урлагийн дурсгал, зан заншлыг устгасан нь аймшигт гэмт хэрэг мөн гэж би бодож байна.

Европоос бидний ихэд хоцорсон учир шалтгаан нь ч энд л байна. Үгүй гэж үү?

Зохиогч: Урлаг бол эрхэм, түүнийг устгах нь аймшигт явдал гэж та зөв хэллээ. Үнэхээр ч Москва цагтаа иж чимэглэлт уран барилга, элбэг баян эд агуурс, үнэт ховор гар урлал бүхий цэцэглэсэн хот байсан л даа. Гэвч тэр бүхэн галд... 1812 оны галд хайлж сүйрсэн билээ. Тэр бол нөхөгдөхгүй хохирол байв. Харин Наполеон монгол хүн байсан хэрэг үү?

200 жилийн урьд Польшууд Москваг үнсэн товрого болгож, тийнхүү оросуудын эрхэм дээд газар шороог Минин, Пожарский нар түрэмгийлэн булаасан шүү дээ. Арай өмнөхөн нь монголчуудтай ямар ч холбоо сүлбээгүй Их Порт (Турк)-ын харьяаны крым хан Девлет-Гирэй гэгч 1571 онд Москваг бас галдсан.

Нэхэн мөшгөвөл эл явдлаас урагш хоёр зуун жилийн тэртээ Чингисийн холын удам Цэнхэр Ордын хан Токтамыш Москваг сүйтгэж байлаа. Тэрээр монголын хаантай холбоо таслахын эсрэг зогссон суздалийн ван Василий ба Семен Димитриевич мөн Олег Рязанский болон нутгийн бусад ноёдыг дэмжиж Москва руу цэрэглэсэн билээ.

Урлаг судлаач: Та Оросыг байлдан эзэлж, татарын талхи-дарлалыг тогтоосон Батын тухай ганц ч үг хэлсэнгүй. Тэр хааны тухай мартчихав уу?

Зохиогч: Яалаа гэж, яалаа гэж. 1216 оноос монголчуудтай дайны байдалд явсан половчуудын эсрэг хөдөлсөн Батын цэрэг 1237— 1238 онд Оросыг дамжин половчуудын ар хударгаар орж, тэднийг мажарын нутгийн гүн рүү ухран дайжихад хүргэжээ. Монголчууд замдаа Рязань болон Владимировын вант улсын арван дөрвөн хотыг эвдэж сүйтгэсэн нь үнэн. Тухайн үед уул нутагт гурван зуу орчим хот балгас байв. Тэр цагт давшигч аль ч цэрэг армийн адил монголчууд бэлэг сэлт базаалгаж, морь мал, хоол ундны зүйлийг олзлон дээрэмдэж байсан боловч оросуудыг алба татварт унагах, хот хороодод нь цэрэг цургаа үлдээж хяналтандаа авах зэргийн алиныг ч хийж явсангүй.

Урлаг судлаач: Гэхдээ л тэд Оросын хотуудын өрлөг ээж буурал Киевийг талхилсан шүү дээ!

Зохиогч: Батаас бүр өмнө, яг хэлбэл 1169 онд Андрей Боголюбский гурав хоногийн хугацаагаар өөрийн цэргийг туйлуулж Оросын нийслэлийг цөлмөж балласан. Харийн хүмүүс л харин хотыг чингэж хөнөөдөг болов уу. 1203 онд Рюрик Ростиславич яг тийм явдлыг давтан үйлдсэн бөгөөд түүнд «Игорын цэргэлсний тууж» зохиолын баатар Игорь Святославич хамжаархан тусалжээ. Чухамдаа Киевээс эвдээд байх юм Батад үлдсэн болов уу даа!...

Урлаг судлаач: Тэгвэл Козельскийг «түйтгэрийн хот» гэж нэрлээд хүн ардыг нь монголчууд зэрлэгээр яргалсныг юу гэж үзвэл зохилтой вэ?

Зохиогч: Үнэхээр тэр эмгэнэлт явдал бусдын дундаас тод ялгарч байгаа юм. Гэвч үүнийг ч бас тайлбарлаж болно. 1223 онд монголчууд половчуудтай байлдахын тул ар тал руу нь гурван түмэн цэрэг шургуулсан аж. Тэр цэрэг Кавказыг даван гүрж, осетин нарыг байлдсаар половчуудын нутаг Дарьялийн хөндий рүү дөхөж очсон байна. Чингэхэд өмнөд оросын бүх вангууд половчуудыг өмгөөлөн боссон билээ. Найрамдах хэлэлцээ байгуульа гэсэн үгтэйгээр оросууд руу очсон монголын элчийг Мстислав, мөн Черногов, Козельскийн вангууд санаачилж амий нь хороожээ.

Цэрэг омгийн байгуулал, ардчиллаас эх сурвалжаа авсан монгол ёс горим гэмт хэргийн төлөөнөө хатуу хариуцлага тохоож байлаа. Тэд төрийн итгэмжит элчийг мэхлэх буюу алж дайсагнахыг хамгийн адгийн явдал гэж үздэг байв. Тиймд хүргэгсдийг хэзээ ч өршөөж байсангүй. Энэ нь ч чухамдаа аргагүй юм. Юу гэвэл Дорнодахинд элч хүнийг эрхэм гийчин хэмээн хүндэлдэг жамтай. Тэд элч нары нь эрхэнд халдсан хотыг л «түйтгэрийн хот» гэж нэрлэж байв. 1228 онд Монголын цэрэг Козельскд тулж очжээ. Монгол ёсоор оросын вангуудын өдөөсөн ялд торгон цэрэг, вангийн зөвлөхүүд, тэдний ахан дүүс бүх л хүн унах ёстой байсан. Үүнийг Козельскийн бус оросууд мэдэж байсан бөгөөд тиймээс ч нэгэн буман цэрэгтэй хир нь тэд Козельскд тус хамжаа болохыг яаравчилсангүй.

Урлаг судлаач: Миний бодоход эртний Орос нь, соёлын үр цэцэглэн мандаж, туульс хайлагч нар дууль зохиож, дахин төрөлтийн үе хөгжлийн босгоноо тулж ирсэн Баруун Европтой л тэр үед түншилж нөхөрлөх хэрэгтэй байсан болов уу. XIII зууны Орос оронд жишээлэхэд «Игорийн цэрэглэсний тууж»-ийг зохиогч зэрэг хүмүүс Европ дахинтай ойрын хэлхээ холбоо тогтоож амжсан тухай Та өөрөө ч бичиж байсан билээ. Би Игорийн талд байна. Ерөөс монголчууд манай түүхэнд хөндлөнгөөс хутгалдаагүй аваас юу болох байсныг төсөөлж үзвэл яасан юм бэ?...

Зохиогч: Уучлаарай, яриагий чинь тасалъя. Төсөөлөхийн хэрэг ердөө үгүй. Монголчууд манай түүхнээ хутгалдан оролцсоноороо XIV зуун гэхэд л Оросод юу өгсөнийг авч үзвэл харин илүү унацтай. Тэгэхэд Залескийн Орос гэж нэрлэгдэж байсан Их Орос сүүлд Батхааны өргөмөл хүү болсон Александр Невскийн хүчин зүтгэлээр Алтан ордтой сайн дураар нэгдсэн юм. Гэтэл нөгөө талд эртний Орос буюу Белорусс, Киевийн вант улс, Галици Волынын хамт ер эсэргүүцэлгүйгээр Литви, Польшид дагаар орсон шүү дээ! За тэгээд хар. Москвагийн эргэн тойронд харин нөгөө л улигт монголын «талхи дарлал»-ын өмгөөлөн эртний хотуудын «алтан бүс» бүтнээр үлдэж, харин Белорусс, Галици-ын тухайд гэвэл оросын соёлын ул мөр нь ч хүртэл баларсан. Новгородаг 1269 онд татаруудын тусламжтайгаар герман рыцаруудын довтолгооноос аварчээ. Татарын тус хамжааг эс хүссэн хот болгон л аль бүхнээ алдаж сүйрч байв. Тэр үеийн газрын зургийг хар л даа. Юрьевийн оронд одоогийн Тарт хэмээх Дерпт, Колыванин байранд — Ревель, одоогийн Таллин. Рига тэгэхэд Двинь мөрний усан замын худалдааг хаачихсан юм. Польшийн Бердичев, Брацлав хоёр цайз нэгэн цагт оросын вангуудын өлгий нутаг байсан «Зэрлэг тал»-д хүрэх замыг хөндөлдөж, үүгээр хэрэг дээрээ Украинд хяналтаа тогтоосон байлаа. Ийм ийм замаар 1340 онд гэхэд Орос нь Европын улс төрийн газрын зургаас арчигдчихсан юм. Тэгээд дөнгөж 1480 онд Орос агсаны зүүн жигүүр нутагт Москва төвлөсөн Их Орос сая дахин төрж билээ. Польшид эзлэгдэн талхигдаж байсан Оросын зүрх-Киевийн Оросыг дөнгөж дангаж XVIII зуунд л аварч чадсансан.

Урлаг судлаач; Тэгвэл яагаад оросын утга зохиолд, жишээ нь, А.К.Толстойн бүтээлд европчууд- Оросын уг ёсны холбоотон, анд нөхөд мэтээр бичдэг болж байна?

Зохиогч: Оросын сэхээтнүүд, тэр дотроо яруу найрагч А. К. Толстой мэтийн эх оронч үзэлтнүүд ч түүхийн асуудалд хомсхон хүмүүс явжээ. Хэрэг дээрээ Орос вангууд шведүүд, англо-саксоныхан, даничуудтай нөхөрлөж, вангуудад нь охид зээ нараа инжилж илгээдэг байсан л даа. Гэхдээ л цагийн өмнө өнгө өөрчлөгдөх хэмээр тэд Оросыг золиодос, колоничлон хазаарлах ээлжийн газар нутаг хэмээн үзэх болсон юм. Ингэхэд нь таатай нөхцөл байдал XIII зуунд бүрэлдэн тогтсон боловч европын рыцар, худалдаачдын замыг монголчууд хөндөлдөн хаажээ. Орос Ливонийн хооронд ээлжит харгалдаан үүсэх үед Их ван Ярослав Ярославич 1269 онд татаруудыг холбоотноор урьж авчирч билээ. Энэ нь германуудыг сүрдүүлж найрамдал эрэн хүсэхэд хүргэж байлаа.

Мэдээжийн Ливонийн рыцарууд, тэдний хамсаатан Ариун рим гүрний хаан, хамба нар 1246 онд Лион дахь их хуралдаан дээрээ татарын эсрэг загалмайтны аян дайн хийхээр тунхаглаж байсны нь ч бодоод үзсэн хэрэг явдал тиймээр эргэсэнд тэд юунд л таатай байхсан билээ. Хэн ч өөрийгөө буруутан болгохыг зүрхлээгүй учир татаруудыг «соёлгүйчүүд», «зэрлэг нүүдэлчид» — хэмээн шоовдорлон нэрлэх аян шалтаг тэр удаад дахин төрсөн юм.

Урлаг судлаач: Гэхдээ л тэр үеийн монголчууд үнэхээр бичиг үсэг үгүй, дүрслэх урлаг ч үгүй байсан шүү дээ.

Зохиогч: За байз тодруулъяа. Та ер нь аль алий нь мэдэхгүй байгаа хүн юм. XII— XIII зуунд нүүдэлчдийн нэлээд хэсэг бадарчин лам нарын нөлөөгөөр христос шашинд орсон байлаа. Нөгөө талд хэдий уйгуржин бичгээр боловч шашин мөргөлийн ном судар монголчууд байсан билээ. Тийм номыг энгийн ард ч уншдаг байв. Харин Франц

Англи, Германд бол бичиг судар дан ганц латинаар учир жирийн хүн ухаж ойлгодоггүй байсан юм. Дүрслэх урлагийн тухайд гэвэл, европын ихэнхи оронд монголын уран зургийн олон сайхан цомог, нэгэн сэдэвт зохиол хэдүй нь хэвлэгдэн гарчээ. Тэр бүхнийг тоочиж ярихын хэрэг ч үгүй, арга ч үгүй, юм.

Урлаг судлаач: Дундад зууны Европ аварга том цайз хэрэм, сүрлэг дугана сүм барьж байлаа. Хүннү, монголчууд ер энэ мэт юм үлдээгээгүй нь юу билээ?!

Зохиогч: Барилга байшинг аж төрж суухын учир босгодог. Хад чулуу хэдүйгээр эсгийнээс илүү эдэлгээтэй ч цайзад илүү чийглэг, илүү хүйтэн байсан нь мэдээж. Дундад зууны үеийн европын тайж, хатагтай нар түлээ түлш ихээр хэрэглэдэг задгай зуухны өмнө урт үдшийг өнгөрөөдөг байв. Оросод ч ялгалгүй хаад, вангуудын зарц, туслах, зэвсэг үүрэгч нар хүртэл дулаалгагүй хүйтэн хонгилд өдөн хөнжил дор унтдаг байлаа. Нүүдэлчний орон байр- гэр нь давхар бүрээстэй байдаг юм, Давхар бүрээсний дунд хургах агаар хүйтэн, халуунаас адил хэмжээнд тусгаарлах үүрэгтэй. Голомтон дахь гал гэрийг хэт улаан туяагаар жигд халаана. Гэр бол багтаамжтайн дээр агаарын солилцоо сайтай. Хаадын гэрт 500 орчим зочин элбэг багтдаг байлаа.

Урлаг судлаач: За тийм байдаг байж. Дундад зууны үеийн европын хатагтай, эрчүүд ямар гоё хувцас өмсдөг байлаа! Гэтэл монголчуудад хамба хилэн ч, хоргой торго ч байсангүй, байх ч үндэсгүй юм. Тэд чинь хонины арьсан дотор л пөөдийж явлаа шүү дээ.

Зохиогч: Нэхий бол өвөлд илчтэй, биенд эвтэйхэн хувцас. Ёслол баяраар монголчууд булга, хэрэмний арьсан дээл өмсдөг байсан бол жишээлэхэд Англид зөвхөн хаад, ноёд л үенгийн арьсан нөмрөг хэдэрч байжээ. Нүүдэлчид хөдөлгөөний асуудлыг тун хялбарханаа шийдэж байв. Тэд морьтой, европын тариачид явган европын баячууд нь л харин илжиг хөлгөлдөг байсан юм. Тийм ээ, нүүдэлчид дурсгалт зүйлс тун хомсхоньг үлдээсэн нь үнэн. Гэтэл эртний оросын модон сийлбэрт уран барилгаас эдүгээ юу ч хоцорсонгүй шүү дээ. Тэгэхлээр монголчуудыг соёл урлагийн дурсгалгүй байсан гэж мэтгэж болохсон уу?

Урлаг судлаач: Та монголчуудад хэт их элэгтэй хүн юм аа даа?!

Зохиогч: Миний хувийн хүсэл сонирхол, сэтгэлийн хөөрөл байрал энд хамаагүй. Би түүхч хүн, тэгээд ч судлаачийн хувьд бодит баримтлаг зүйлд л итгэдэг билээ. Орос ван, язгууртнууд нутгийнхаа хажуу бөөрөндөх Ливаны католок цэрэглэсэн улс, түрэмгий рыцаруудын тэргүүн анги-Польш, мөн худалдаачдын Ганзаас харь холын нутаг дахь төдий л хүчирхэг бус Алтан Ордоор холбоотноо хийх нь давуу ашигтай гэж үзэж байсныг би батлан хэлэх байна. Хүчирхэг Византи гүрэн оршин тогтнож байх үед христос, мусульман нарын аль аль нь оросын газар шороонд заналхийлж чаддаггүй байжээ. Харин 1204 онд загалмайтнууд Константинополийг эзлэн авч сүйтгэсэнээр оросууд цорын ганц холбоотноосоо хагацахад хүрчээ. Византи нь 1261 он хүрч байж сая сул дорой жижиг улсын хэлбэрээр дахин сэргэсэн билээ. Хань холбоотонгүйгээр улсын хэргийг хөтлөх боломжгүйгээс чухам тэр үед хагас христос шашинтны орд, христос шашинтны Орос хоёрын холбоо үүсчээ. Уг холбоо 1312 он хүртэл буюу хан Узбек лалын шашинд орох үе хүртэл үр ашигтайгаар уламжлагдсан байна. Та энэ бүхнийг ер ойлгохгүй байна гэж үү?

Урлаг судлаач: Би өөрийн дадаагүй юманд итгэж чаддаггүй хүн. Ярьсан хэлснийг чинь сайшаан дэмжиж нэг л болохгүй байна.

Өөр нэг хуучлагч (биеэ өндөрт бодсон зохиолч): Тэр үеийн монголчууд овог ч үгүй, удам судар ч үгүй олиггүй новшууд байжээ. Чингис бол ард түмнээ мэхэлсэн залихай амьтан мөн. Тэгээд ч Чингис ард түмэндээ харь хүн байв. Тэр чинь монгол биш. Зүс нь цагаан шаргал шүү дээ. Цэрэг нь ч өөрцгүй монгол биш. Тахин шүтлэг, харгислал, айхын аюумшигээр нэгтгэгдсэн олон омгийн хольц байлаа.

Зохиогч: Тэгээд ганц хүн яахин Монголыг нэгтгэж, өөрөөсөө хүчирхэг хөршүүдийг ялж яллаж байсан байж таарах билээ!

Зохиолч: Түүнд «Их зоригийн хүмүүс» гэгдэх хорон санаатнууд тусалсан юм. Тэд Иргиз гол дээр Мэргэд омгийнхныг цохиж, 1216 онд баруун зүг одох замыг цэвэрлэж өгчээ.

Зохиогч: Монголчууд тэндээс Долоон гол (Семиречье), хатан руу хөдөлсөн. Энэ бол баруун зүг биш, зүүн өмнө зүг. Дараа нь Иргизээс зүүн тийш орших Отрарыг авсан.

Зохиолч: Ялгаа нь юу билээ. Монголын цорын ганц зорилго бол дээрэм хийх явдал байв. Эс тийм бөгөөс юунд тэд Кидан, Мэргэд, Найманы суурьшсан тал нутаг, зөрчид, тангадын улс, Солонгос, Энэтхэг, Азербайджан болон олон олон өөр нутаг орон руу халдан довтолсон байж таарах вэ?

Зохиогч: За, за... Бүү дошгир. Аятайхан сууж ярилцъя. Тайгад нутагтай мэргэд, талд Чингистэй хөршилж байсангүй. Тэд 1200 онд Чингисийн улсын эсрэг дайнд хөдөлсөн бөгөөд бут ниргэгдтэлээ хааны эсрэг боломжийн бүхий л холбоо гороонд орж явлаа. Найман гэвэл монголын талд эзэн зуух гэж Чингистэй өрсөлдөж босоод 1204 онд ниргэгдсэн. Гэвч монголчууд тэднийг өөрийн талд нэгтгэсэн юм. Монгол нь Солонгост үнэхээр дайлаар орж, алба тулгасан явдал бий. Энэтхэгийн тухайд болбоос Монгол цэрэг хорезмыхныг нэхэж тэнд хүрсэн. Хүрсэн дороо л буцсан. XIII зуунд тийм улс гүрнүүд байгаагүйгээс авч үзсэн ч Афганистан, Иран, Азербайджаныг монголчууд дайлаагүй гэж хэлж болно. Эд улсын нутаг дэвсгэр Мухамедын хүү Хорезмын хаан Желель Ад-Диний эзэмшил нутаг байв шүү.

Зохиолч: Оросын дайсан, нүүдэлчдийг бахдан магтах нь эх оронч үзэлд эс нийцнэ!

Зохиогч: Тэгээд угсаа дээдсээ гүтгэж гүжирдэх нь эх оронч үзэл үү? Таны бодлоор газар газраас цугларсан унхигар «новшууд» хэрцгий ноёдоосоо айсандаа л тоо, зэвсэг, хангамжийн хувьд давуутай орос цэргүүдийг толгой дараалан хяргачихсан болж таарах нь уу?! Бидний өвгүүд тийм өчүүхэн хулчигарууд байлаа гэж үү? Батын «довтолгоо» бол үнэхээр морин цэргийн томоохон хэмжээний аян дайн байсан болоод дараа дараачийн үйл явдлууд нь зөвхөн шууд бус замаар л тэр аянтай холбогдож байна. Түүх бол тийм ч хялбархан тайлагдах оньсого биш ээ. «Бичсэн шүлгээ тайлбарлаж чадахгүй яруу найрагч мөнхийн гутамшиг» гэсэн Дантен үгийг зохиолч хүн эрх биш харгалзан тогтоох ёстойсон?!

Эх сурвалж судлаач (хатуу бөгөөд, эрдэмтэй хүн): Эв эеийн эрдэмгүй түрэмгий мунхаг хүнтэй хуучлахын хэрэг юун. Дорнодахинд «Жингэр ульж л байна. Жин явж л байна» гэсэн зүйр үг бийсэн. Эх түүхнээ жинхэнэ ёсны чухал, шийдэгдээгүй олон асуудал байсаар байхад жингэрийн улихыг та ингэтлээ их чагнаарахад нь юу билээ.

Зохиогч: Түүхийн алив үед мэдлэг дорой гэнэн итгэмтгий уншигч цөөнгүй байсан. Тэр дотроос шинжлэх ухааныг үлгэрээр солих хандлагын хүмүүс тодорчээ. Гэвч бас хөөрхийсийг буруутгаж болохгүй. Эрдэмтэд бүхий л уншигчдад зориулж туурвилаа бүтээдэг. Иймд эрдэм-

тэд л үйл явдлын жинхэнэ учрыг тайлбарлаж, бусдын судалгаанаас зөвхөн үнэн баримт, туршлага хоёроор нотлогдсон шалгарлыг хүлээн авч байх хэрэгтэй гэдэгт дууриалал болох учиртайсан билээ.

Сурвалж зохиол судлаач: Таны зөв бололтой. Би тантай өөр сэдвийн хүрээнд ярилцъя уу гэсэн юм. Дундад зууны үеийн европын бүх зохиогч монголчуудын тухай эрс муу үгээр бичиж ирснийг бид мэднэ. Яагаад тэр юм бэ?

Зохиогч: Энэ үнэн. Гэхдээ бүх европчууд уу, биш үү! XIII зуунд европынхон хоёр бүлэгт хуваагдаж байв. Нэгдэх бүлэгт ромын папыг дэмжигч гвельфууд, хоёрдахь бүлэгт нь эзэн хааныг дэмжигч гибеллинууд орно. Гвельфуудын талд Анжу овгийн баруун өмнөд зүгийн францчууд, Вальф овогтой герцогуудын саксоны удам угсаа болох зүүн хойд герман, Италын тэн хагас, түүнчлэн католик шашны цэрэг тайж нар байлаа. Гогенштрауфен овогтой швабын холбооны герцогууд гибеллинуудын талд явсан бөгөөд тэднийг Францын капетинги овгийн хаад дэмждэг байв. Гибеллинууд нь мөн Никейн эзэнт улс, Армяны хаант улс, Бага Азийн нэгэн муж болох Киликия, мөн Монголын христос шашинтан зэрэг дорно дахины христосчуудын тусламжид дулдуйдаж байсан юм. Иймээс Ромын пап тэдний, сүмд орох эрхийг хязгаарлаж байлаа.

XIII зууны Европт хүчний харьцаа ийм байсан нөхцөлд монголчуудын тухай худал үг ихээр тархаж газар авсан нь ойлгомжтой бөгөөд ингэхлээр тэр цуу яриаг нэгтгэн «хар домог» гэж нэрлэвэл зохилтойяа. Ингэхлээр «Хар домог» дан ганц европын түүх зүйд ч хамаарагдахгүй нь мэдээж.

Англи, германы үзэг нэгт нөхөд нь XVI—XVII зууны испаны конкистадоруудын тухай бичихдээ хар будаг хармалдаггүйд нь колонийн түрэмгийллийн үеийг судлаач испаны түүхчид гоморхдог билээ. Үнэндээ ч тэд хэрцгий л дайнчид байсан. Гэвч англи-францын далайн дээрэмчид, америкийн «хуйхны» ангуучид, францын корсарууд, тэнгэс, далайд хонжоо хайсан английн «ёсорхог» харцуулууд, боолын худалдаачид, Индонези дахь голландын тариалангийн эзэд тэднээс юугаараа ялгаатай байлаа?!

Зохиолчид адал явдалт романдаа зөвхөн баяжихыг хүссэн жирийн л алдарт европ хөвгүүдийн дүрийг дөвийлгөн дүрсэлсэн нь олонтой. Энэ нь уншигчдын дунд колонийн түрэмгийллийг магтаархах, колоничлогчдын балмад хэргийг хүнлэг гавьяа мэт үзэх ойлголтыг нэрж төлөвшүүлжээ.

Харин испанчуудыг «сайн талын баатруудын» тоонд оруулахгүй гадуурхдаг юм. Тэднийг хэрцгий гэмт хэрэг үйлдсэн, мексик, перугийн сүмүүдийг дээрэмдэж тоносон, Карибын тэнгэрт корсаруудтай байлдсан гэж янз бүрээр зэмлэж буруутгана. Тиймэрхүү явдал гарах нь ч гарсан л даа.

Эхнэрүүдээ илбэ увидсын хэрэгт холбогдох үед Шинэ выглийн протестант шашинтангууд Испаны Севил хотынхны заншлаас ч хол давран амьдаар нь галд шатааж байлаа. Европоос нүүдэллэн очигчид америкийн цөөн тооны индианчуудыг устгаж, нутгийн зэрлэг үхэр, минж зэрэг амьтныг цөлмөн, газар нутгийг нь эзэрхэн дээрэмдэж, Виргини мужийн (АНУ) тариалангийн эзэд удаан хугацаанд нэг төрлийн хөвөнгийн ургамлыг тариалснаар дулаан орны үзэсгэлэнт ой модыг элсэн цөл болгон хувиргасан зэрэг явдал бий.

Товчоор хэлэхэд хэн нь ч хэнээсээ төдий л ялгаагүй нь бидэнд ажиглагдана. Флибустьерууд (англи-францын далайн дээрэмчид), скваттерууд-

даас (америкийн уугуул ард түмний газар нутгийг булаан эзэлсэн европынхон) конкистадорыг илүү ад шоо үзэж шүүмжлэх нь шударга бус хэрэг гэж испанчуудын үзэж байгаа нь зөв юм. Иймээс ч тэд түүхийг өрөөсгөлөөр тайлбарласан явдлыг «хар домог» гэж нэрлэжээ.

Испанчуудын тухай «хар домог» протестант шашны суртал ухуулгын ид өрнөлтийн үед, хэвлэлийн соёл ихэд хөгжсөн протестант орнуудад үүссэн учраас тайлбарлахад хялбар байдаг. Харин монголчуудын тухай «хар домог» нь Баруун Европод тархахдаа XIII зуунд бус, бүр хожим XIV зуунд үүсэж, XX зуун хүртэл төлөвшсөн болохоор бичиг баримтын хувьд эзгүйдэж тайлбарлахад маш бэрх болж байгаа юм.

Энэ мэт үнэнийг гуйвуулсан хандлага төрдөг нь санамсаргүй хэрэг биш ээ. 1260 онд Монголын христинууд «үхлийн ноён» мусульманчуудаас Палестиныг чөлөөлөхөөр ороход, тэндэхийн тамплиерууд мамлюкуудаа (Христосын шүтээнийг хамгаалж байсан загалмайтнууд) туйлдаж эцсэн монгол цэргүүдийн гүнд нэвтрүүлсэн хийгээд цаадуул нь сири, армяны христос шашинтнуудыг устгаж эхэлсэн бөгөөд тамплиерууд тэдэнд ямар ч тусламж үзүүлэлгүйгээр Киприйн тийш зугатаж, тэндээсээ Европ руу нэвтэрчээ.

Европод иймэрхүү урван тэрслэх явдлыг үзэн яддаг байлаа. Гэвч тамплиерууд тарьсан бүх нүглээ монголчуудад тохож, нэрээ цэвэрлэж амжсан юм. Улмаар худал гүтгэлгийн үр шинэ үеийн түүхнээ идээшин ургаж, XVIII зуунд маш эрчимтэйгээр цэцэглэсэн байна. Энэ үед Оросын хүчирхэг болсныг европчууд монголчуудын улсын дахин сэргэлт хэмээн үзэж байлаа. Ийнхүү урвагч тамплиеруудын гайгаар европын түүх татар, монгол, орос үндэстнийг «зэрлэг азичууд» хэмээн доорд үзэж, нэр хүндтэй соёл иргэншил бүхий өрнөдийгөө магтан дуулах болжээ.

Домог үнэн бодит зүйлээс илүү хурдан тархаж, хүмүүст итгэгдэх үнэмшил ихтэй учир Монголын тухай «хар домог» Европт, дараа нь манай Оросод уламжлагдан дэлгэрсэн нь энээ.

Сурвалж зохиол судлаач: Тийм ээ, сурвалж зохиолд шүүмжлэлтэй хандах хэрэгтэй. «Монголчуудын байлдан дагууллыг үй түмээр сүрэглэсэн дайснуудын довтолгоон» гэж үзэж байсан хуучин төсөөллийг В. В. Бартольд бүр 1896 онд няцаасан билээ. Тэрээр Монголын нэгдсэн төр байгуулагдсаныг хувь хүмүүс, омгуудын хоорондын тэмцэлтэй холболгүй, харин язгууртан ноёд, ард түмний хоорондын тэмцэлтэй холбож үзжээ.

Зохиогч: Та тэгвэл В. В. Бартольдтой санал нэгтэй байна уу?

Сурвалж зохиол судлаач: Харин л дээ... Академич Б.Я.Владимирцов, С.А.Козин хоёр түүний тайлбарыг зөвшөөрөөгүй. Мөн түүнтэй санал зөрж илт маргалдсан А.Ю.Якубовский нь Г.Е.Грумм Гржимайло, Р.Груссе нарын таамаглалыг адил хэмжээнд ширүүхэн шүүмжилсэн атлаа өөрөө тууштай санал дэвшүүлээгүй юм. Би бол суурьшлын биш, нүүдлийн ард түмний судлалаар мэргэжсэн хүн. Тухайн асуудлаар надад хувийн санал бодол алга...

**Орчуулсан Д. Маам
О. Оюунгэрэл**

(Төгсгөл нь дараагийн дугаарт)